



МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2000. оны 7 сарын 31-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот


Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантурт суралцуулах ажлыг зохицуулах, зохион байгуулах, суралцах хүмүүсийн талаар дүгнэлт гаргах комисс"-ын 2000 оны 7 дугаар сарын 7-н, 8 дугаар сарын 2-ний өдрүүдийн хуралдааны тэмдэглэл, 1998, 1999 оны өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлтийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хавсралтад нэр дурьдсан хүмүүсийг 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн өндөр хөгжилтэй орны их, дээд сургуулиудын магистрантур, докторантурт суралцуулсугай.

2. АНУ-ын Колорадогийн Их сургуулийн магистрантурт суралцаж буй Я.Батбаярын суралцах хугацааг нэг семестрээр, ХБНГУ-ын Берлин хотын Техникийн Их сургуулийн докторантурт суралцаж буй Магвандорж овогтой Бямбадорж, ОХУ-ын Москва хотын Олон улсын харилцааны дээд сургуулийн магистрантурт суралцаж буй Гурбазар овогтой Батбаяр нарын суралцах хугацааг тус бүр нэг жилээр сунгасугай.

3. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.



САЙД

А.БАТТӨР

Гэгээрлийн сайдын 2000 оны
192 дугаар тушаалын хавсралт

№	Овог, нэр	Мэргэжил	Улс, сургууль	Суралцах хугацаа /жил/
1~	Л. Амарсайхан	Байгаль орчин	АНУ-ын Колорадогийн Их Сургуулийн магистрантур	2
2	Н. Оюунбилэг	Биологи	ХБНГУ-ын Бөхүм хотын Рүүрийн Их Сургуулийн докторантур	3
3	Л. Энхтувшин	Мал эмнэлэг	Австрали улсын Сиднейн Их Сургуулийн магистрантур	2
4	А. Эрдэнэбулган	Улс төр	АНУ-ын Колорадогийн Их Сургуулийн магистрантур	2
5	С. Батболд	Физик	АНУ-ын Пүрдүгийн Их Сургуулийн магистрантур	2
6	Л. Ганбаяр	Эдийн засаг	Австралийн Сиднейн Их сургуулийн магистрантур	2
7~	Б. Төмөрбат	Математик	БНҮҮ-ын ШУА-ийн Математикийн хүрээлэнгийн докторантур	1
8~	Б. Буяндэлгэр	Боловсрол судлал	ОХУ-ын Москва хотын Багшийн Их сургуулийн докторантур	1
9	С. Туяа	Хиймэл дагуулын мэдээ боловсруулалт	Япон улсын Чибагийн Их сургуулийн магистрантур	2
10	Б. Баттулга	Мэдээлэл зүй	Франц улсын Эколе Супериор Электрисите сургуулийн докторантур	1
11	Б. Алтан-Од	Бизнесийн удирдлага	Австрали улсын Свинберний Их сургуулийн магистрантур	2
12	Н. Энхбат	Төрийн захиргааны удирдлага	АНУ-ын Идахогийн Их сургуулийн магистрантур	2
13~	Д. Алтанхүү	Бизнесийн удирдлага	АНУ-ын Техасийн Велслейний Их сургуулийн магистрантур	2
14~	А. Энхгэрэл	Анагаах ухаан	ХБНГУ-ын Берлин хотын Гумбольдтын Их сургууль	1
15	Р. Бизьяа	Олон улсын харилцаа	ОХУ-ын Москва хотын ГХЯ-ны дэргэдэх Дипломатын академи	1
16	П. Ганхуяг	Улс төр	Япон улсын Токио хотын Аояма Гакугийн Их сургуулийн магистрантур	2